



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2005 оны 9 сарын 16 өдөр

Дугаар 371

Улаанбаатар хот

**Нийслэлийн өмчит үйлдвэрийн
газар байгуулах тухай**

Монгол Улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай" хуулийн 78 дугаар зүйлийн 1 дүгээр заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2005 оны 55 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Усан спорт сургалтын төв нийслэлийн өмчит төсвийн байгууллагыг 2005 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн Усан спорт сургалтын төв нийслэлийн өмчит үйлдвэрийн газар болгон өөрчлөн байгуулсугай.

Хоёр. Усан спорт сургалтын төвийн дүрмийг хавсралтаар баталсугай.

Гурав. Тус төвийн дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар /Ц.Болдсайхан/-т үүрэг болгосугай.

Дөрөв. Усан спорт сургалтын төв нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэн ажиллуулахыг Өмчийн харилцааны газар /М.Цэрэндорж/, Усан спорт сургалтын төв /Ш.Дөрвөнжин/-д даалгасугай.

Тав. Энэ захирамж гарсантай холбогдуулан нийслэлийн Засаг даргын 2001 оны 208 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

М.ЭНХБОЛД



УСАН СПОРТ СУРГАЛТЫН ТӨВ (НӨҮГ)-ИЙН ДҮРЭМ

• Нэг. Ерөнхий зүйл

1.1 Усан спорт сургалтын төв (УССТ) нь Нийслэлийн өмчид үндэслэн байгуулагдсан улсын үйлдвэрийн газар хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулна.

1.2 Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нөхөрлөл, компаний тухай хууль бусад холбогдох хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тогтоол, Нийслэлийн Засаг даргын Захирамж, үйл ажиллагааны хөтөлбөр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

1.3 Усан спорт сургалтын төвийн зорилго нь нийслэлийн хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, усан спортын усанд сэлэлтийн төрлөөр хичээллэгчдийг сургах, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг голчилж, усанд сэлэлтийн мэргэжлийн сургалт явуулж, бусад бассейн бүхий чийрэгжүүлэлтийн газруудад эрүүл ахуй, халдваргүйжүүлэлт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх түшиц байгууллагын хэмжээнд ажиллана.

1.4 Усан спорт сургалтын төв нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний харилцаанд ордог хуулийн этгээд мөн.

1.5 Усан спорт сургалтын төв нь тогтоосон журмын дагуу хийгдсэн тэмдэг, бэлэгдэл, албан бичгийн хэвлэмэл хуудас, банкинд харилцах данстай байна.

1.6 Усан спорт сургалтын төв нь Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт, Залуучуудын өргөн чөлөөнд байрлана. Утас: (976-11)-325569, факс: (976-11)-325386

• Хоёр. Удирдлага зохион байгуулалт, үүсгэн байгуулагчийн эрх

2.1 Усан спорт сургалтын төвийн захирлыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилж, чөлөөлнө.

2.2 Усан спорт сургалтын төв нь үйл ажиллагаагаа нийслэлийн Засаг даргын орлогч, ЗДТГазар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, өмчийн харилцааны газрын удирдлага дор явуулж ажлаа тайлагнана.

2.3 Усан спорт сургалтын төвийн дүрмийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч батална.

2.4 Усан спорт сургалтын төвийн захирал нь байгууллагын бүтэц, дотоод журам, орон тоо, цалингийн хэмжээ, урамшууллын журмыг тогтоож мөрдүүлэх ба албан хаагчдыг томилж, чөлөөлнө.

2.5 Усан спорт сургалтын төвийн захирал нь эрх хэмжээнийхээ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжинд нийцүүлэн тушаал гаргаж, байгууллагын эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажиллагааныхаа зорилгод ашиглаж эзэмшинэ.

2.6 Усан спорт сургалтын төвийн захирлын эрх үүрэг, хариуцлага, цалин хөлс, урамшуулал болон бусад харилцааг Нийслэлийн өмчит үйлдвэрийн газрын Захиралтай байгуулах гэрээгээр зохицуулах бөгөөд энэхүү гэрээг Өмчийн харилцааны газар, үйл ажиллагааны чиглэлээр Ерөнхий менежертэй гэрээ байгуулан ажиллана.

Гурав. Усан спорт сургалтын төвийн үйл ажиллагааны эрх хэмжээ

3.1 Усан спорт сургалтын төвийн статусыг оорчлох тухай шийдвэр гарсан өдрөөс компаний тухай хуулинд заасан журмаар бүртгүүлж хуулийн этгээдийн эрхтэй болно.

3.2 Усан спорт сургалтын төв нь өөрийн нэрийн өмнөөс гадаад, дотоодын байгууллагатай эрх зүйн харилцаанд орох, эд хөрөнгө болон эд хөрөнгийн бус эрх эдлэх, үүрэг хүлээх түүнчлэн шүүх, арбитрайн байгууллагад нэхэмжлэгч буюу хариуцагчаар оролдоно.

3.3 Усан спорт сургалтын төв нь банкинд өөрийн харилцах төгрөгийн болон валютын данстай байна.

3.4 Усан спорт сургалтын төв нь өөрийн салбар нэгж байгуулан ажиллуулж болно.

3.5 Усан спорт сургалтын төв нь үйлчилгээний үнийн саналаа Нийслэлийн Засаг даргын Захирамжаар байгуулагдсан үнийн комисст оруулан зөвшилцөж шийдвэрлэнэ.

3.6 Ашиглалт, засварын ажилд шаардагдах түүхий эд, материал, тснэг төхөөрөмжийг гадаад, дотоодын зах зээлээс бие даан бэлтгэнэ.

3.7 Усан спорт сургалтын төв нь дараах хөрөнгийн эрх үүрэгтэй.

а) Өөрийн эд хөрөнгийн бүрэн байдлыг хангаж үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглана.

б) Үндсэн хөрөнгийг холбогдох хууль тогтсомжинд заасан эрх хэмжээнийхээ дотор захиран зарцуулна.

в) Төвлөрсөн болон Нийслэлийн төсвөөс олссон хөрөнгийг төсвийн хууль зардлын зориулалтын дагуу зарцуулж тайлаглана.

г) Ажил үйлчилгээ үзүүлсний үр дүнд олсон ашгийг эрх бүхий байгууллагаас тогтоосон нормативт хэмжээгээр үлдээж хууль, тогтоомжийн дагуу захиран зарцуулна.

д) Үндсэн хөрөнгөд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн бус этгээдэд эзэмшүүлэх, ашиглуулах, шилжүүлэх болон худалдах, хувьчлахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журмыг баримтлана.

3.8 Усан спорт сургалтын төв нь дор дурьдсан үйл ажиллагааг явуулна.

а) Хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх

б) Усан спортын усанд сэлэгтийн төрлөөр хичээллэгчдийг сургах, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлэх

в) Усанд сэлэлтийн мэргэжлийн сургалт явуулах, тамирчин бэлтгэх

г) Чийрэгжүүлэлтийн зориулалттай бассейн бүхий газарт эрүүл ахуй, халдваргүйжүүлэлт, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар мэргэжлийн зөвлөгөө өгөх түшиц байгууллагын хэмжээнд ажиллах зэрэг болно.

Дөрөв. Усан спорт сургалтын төвийн удирдлага, түүний эрх үүрэг

4.1 Захирал нь дүрэм болон гэрээнд заасан хугацаанд тогтоож өгсөн эрх хэмжээний дотор төвийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдана.

4.2 Захирал Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч, Захирагчийн ажлын албаны дарга, Нийслэлийн өмчийн харилцааны газрын өмнө ажлаа тайлагнана.

4.3 Захирал дэргэдээ зөвлөл байгуулан ажиллаж болно.

4.4 Захирал нь төвийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлэлцээрийг Нийслэлийн өмчийн харилцааны газраас олгосон эрх хэмжээний дотор хийнэ.

4.5 Захиралтай холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд Нийслэлийн өмчийн харилцааны газраас томилсон ажилтан төвийг төлөөлөн оролцоно.

4.6 Захирлын эдлэх эрх, хүлээх хариуцлагын хэмжээ хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг гэрээнд тусгана.

4.7 Захирал дараах эрх, үүрэгтэй.

а) Захирал нь ажилтныг ажилд авах, чөлөөлөх, сахилгын арга хэмжээ авах, тэдний цалинг тогтооно

б) Усан спорт сургалтын төвийг гадаад, дотоодод итгэмжлэлгүйгээр төлөөлөх, зарим тохиолдолд итгэмжлэл олгоно

в) Усан спорт сургалтын төвийн нэрийн өмнөөс эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж гэрээнд заасан эрх хэмжээний дотор захиран зарцуулна.

г) Усан спорт сургалтын төвийн бизнес төлөвлөгөө боловсруулж Нийслэлийн өмчийн харилцааны газраар хянуулж батлуулан биелэлтийг хангана.

д) Усан спорт сургалтын төвийн үйлдвэрлэл, технологийн нууцад хамаарах мэдээллийг тогтооно.

е) Хөдөлмөрийн хууль тогтоомжинд нийцсэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлнэ.

ж) Тогтоосон журмын дагуу анхан шатны бүртгэлийг хөтөлж нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл, статистикийн мэдээ гаргах ажлыг зохион байгуулж тэдгээрийн үнэн зөвийг хариуцна.

з) Маргаантай асуудлаар төвөө төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргана.

и) Эрх хэмжээнийхээ хүрээнд төвийн хэмжээнд дагаж мөрдөх тушаал, заавар гаргана.

к) Нийслэлийн удирдлага, өмчийн харилцааны газраас захиралд эрхэлсэн ажлын чиглэлээр тусгайлан даалгасан үүргийг хэрэгжүүлнэ.

л) Хууль тогтоомжинд заасан бусад бүрэн эрх, үүргийг эдэлнэ.

4.8 Захирал нь хувийн эрх ашгийн үүднээс төвийн нэрийг ашиглан гэрээ хэлцэл хийхийг хориглоно.

Тав. Эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, хяналт

5.1 Усан спорт сургалтын төвийн эд хөрөнгө, санхүүгийн бүртгэл, тайланг Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу явуулна.

5.2 Усан спорт сургалтын төвийн санхүүгийн жил нь тухайн оны 01 дүгээр сарын 01-нээс эхэлж, 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна. Санхүүгийн анхны жил нь Усан спорт сургалтын төв байгуулагдсан өдрөөс эхэлж хуанлийн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусах ба санхүүгийн сүүлчийн жил нь төвийг татан буулгасан өдрөөр дууссанд тооцно.

5.3 Усан спорт сургалтын төв нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу орлогын болон бусад татвар хураамжийг төлнө.

5.4 Усан спорт сургалтын төв нь анхан шатны бүртгэлийн баталгаажсан баримтыг үндэслэн дэлгэрэнгүй ба хураангуй бүртгэл хөтлөн, тайлан тэнцлийг улирлаар гаргаж, татварын алба, санхүүгийн байгууллагад тушаана.

5.5 Усан спорт сургалтын төв нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийг тооцно.

5.6 Усан спорт сургалтын төвийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих үүргийг хууль тогтоомжинд заасан байгууллага хэрэгжүүлнэ.

5.7 Усан спорт сургалтын төвийн удирдлага нь төвийн үйл ажиллагаанд шалгалт хийхэд шаардагдах бүх баримт материалаар хангана.

5.8 Усан спорт сургалтын төвийн тооцоо, тайлангийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлнэ. Бэлэн мөнгө болон банкинд хадгалагдаж буй мөнгөн хөрөнгө түүнчлэн орлого, зарлага, төлөгдөөгүй өр зэрэг нь анх оруулсан валютын хэлбэрээр байна. Нягтлан бодох бүртгэлийн бичилт хийх зорилгоор төгрөг хөрвүүлэхэд Монгол банкны тухайн үеийн албан ёсны ханшаар тооцно.

5.9 Үндсэн хөрөнгөнд хамаарах эд хөрөнгө олж авах, төрийн өмчийн тус этг.Эдэд эзэмшүүлэх, ашиглуулах болон худалдах, хувьчлахдаа төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулинд заасан журмыг баримтлана.

Зургаа. Байгуулах, бүртгэх, өөрчлөх, татан буулгах

6.1 Нийслэлийн Засаг дарга богоод Улаанбаатар хотын Захирагчийн санал болгосноор Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төвийг үүсгэн байгуулах, татан буулгах асуудлыг шийдвэрлэнэ.

6.2 Усан спорт сургалтын төвийг татан буулгах тохиолдолд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон комисс уг ажлыг эрхэлнэ.

6.3 Татан буулгах комисс нь дуусгалтын тайпан тэнцэл гаргуула, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, нийтэд мэдээлж, өр төлбөрийг хуульд заасан дараалал, журмын дагуу төлсөний дараа үлдсэн хөрөнгийг 3 сарын дотор Нийслэлийн өмчийн харилцааны газарт шилжүүлнэ.

Долоо. Хариуцлага

7.1 Усан спорт сургалтын төвийн албан тушаалтан нь байгууллагын дүрэм, дотоод журамд заасан үүргийг биелүүлж, байгууллагын ашиг сонирхлын төлөө шударгаар ажиллана.

7.2 Монгол Улсын хууль тогтоомж, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын Захирамж, шийдвэрийн биелэлтийг хэрэгжүүлэх явцад буруу шийдвэр гаргаж, бусдад хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон бол холбогдох хуулийн дагуу хариуцлага хүлээнэ.

7.3 УССТөвийн захирал нь эрх мэдлээ хэтрүүлэх буюу урвуулан ашиглаж, байгууллагадаа хохирол учруулсан бол өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөрөө бүрэн хариуцна.

Найм. Бусад

8.1 Энэхүү дүрмэнд Нийслэлийн Засаг даргын Захирамжаар нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд тэдгээр нь дүрмийн салшгүй хэсэг болно.

8.2 Энэхүү дүрмэнд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдэж бүртгүүлнэ.